

Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооны
2012 он 02 дугаар сарын 15-ны өдрийн
34 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр: “Шивээ Овоо” ХК

Хаяг, утас: Говь сүмбэр аймаг Шивээ говь сум

Хурал хуралдах огноо, цаг газар: 2015 оны 11 дүгээр сарын 4-ны өдрийн 14.00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, “Шивээ Овоо” ХК-ийн төлөөлөгчийн газрын хурлын танхимд, Улаанбаатар хот баянзүрх дүүрэг, 18-р хороо, Манлайбаатар дамдинсүрэнгийн гудамж, Багануур ХК-ийн төлөөлөгчийн газрын 101 тоот

Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо: 2015 оны 09 дүгээр сарын 29-ны өдөр

Олон нийтэд зарлах огноо: 2015 оны 10 дугаар сарын 5-ны өдөр

Бүртгэх өдөр: 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдөр

Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх огноо: 2015 оны 10 дугаар сарын 16-ны өдөр

Хүргүүлсэн огноо: 2015 оны 10 дугаар сарын 4-ны өдөр

Хурлын баримт, бичгийн хуудсын тоо ширхэг, хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА
/...../ оны дүгээр сарын –ний
өдөр

ХҮЛЭЭН АВСАН : БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
/...../ оны дүгээр сарын –ний
өдөр
.....

Дээрх мэлээллийг, хавсралт материалын хамт 2 хувь үйлдэж Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д тус тус ирүүлнэ

“ШИВЭЭ ОВОО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

2015 оны 10 дугаар сарын
4-ны өдөр

Улаанбаатар хот

“Шивээ Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2015 оны 11 дүгээр сарын 4-ны өдрийн 14.00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, “Шивээ Овоо” ХК-ийн төлөөлөгчийн газрын хурлын танхимд хуралдаж дараах асуудлыг хэлэлцэнэ.

1. Компанийн дүрмийн 4.1 дүгээр зүйлд Зарласан хувьцааны тоог 23,680,766 ш болгох өөрчлөлтийг оруулах тухай
2. Компанийн дүрмийн 12.6.3-дугаар заалтыг Компанийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн эд хөрөнгө худалдан авах, үндсэн эд хөрөнгийг данснаас хасах актлах асуудлыг толгой компаниас ирүүлсэн удирдамжийг үндэслэн компанийн ТУЗ шийдвэрлэнэ гэж өөрчлөн найруулах тухай
3. Компанийн дүрмийн 10.9 дүгээр заалтыг хасах тухай
4. “Шивээ Овоо” ХК-ийн заралсан хувьцаанаас 10,261,665 ширхэг хувьцааг хөрөнгийн зах зээлд нэмэлтээр гаргаж нийтэд гаргах худалдах тухай;
5. Шинээр нийтэд худалдахаар гаргаж буй хувьцааг хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлүүлэх эсэх тухай
6. Хөрөнгийн зах зээлд нийтэд санал болгон худалдах хувьцааны санал болгох нэгжийн үнийг тогтоох тухай

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөр эчнээгээр санал өгөх хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүлээн авах эцсийн өдрийг 11 дүгээр сарын 4-ны өдрийн өглөөний 10:00 цагаар тасалбар болгоно.

Хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын холбогдох материалтай 2015 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн “Шивээ Овоо” ХК-ийн төлөөлөгчийн газар, харьяа брокер диллерийн компани дээрээ ирж танилцан хуралдаа идэвхтэй оролцоно уу.

Хурал хуралдах газрын хаяг:

Улаанбаатар хот баянзүрх дүүрэг, 18-р хороо,
Манлайбаатар дамдинсүрэнгийн гудамж,
Багануур ХК-ийн төлөөлөгчийн газрын 101 тоот Шивээ Овоо ХК-ийн төлөөлөгчийн газар,

Лавлах утас: 99068713, 99000249



**“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2015 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчидийн ээлжит бус
хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2, Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоол, Засгийн газрын 2015 оны 330 дугаар тогтоол, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн ТУЗ-ийн 9 дүгээр сарын 15-ны өдрийн 27 дугаар тогтоол, “Шивээ Овоо” ХК-ийн дүрмийн 11.5.1 дэх зүйлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2015 оны 11 дүгээр сарын 4-ны өдрийн 14.00 цагт Монгол улс, Улаанбаатар хот, “Шивээ Овоо” ХК-ийн төлөөлөгчийн газрын хурлын танхимд хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.

1. Компанийн дүрмийн 4.1 дүгээр зүйлд Зарласан хувьцааны тоог 23,680,766 ш болгох өөрчлөлтийг оруулах тухай
2. Компанийн дүрмийн 12.6.3-дугаар заалтыг Компанийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн эд хөрөнгө худалдан авах, үндсэн эд хөрөнгийг данснаас хасах актлах асуудлыг толгой компаниас ирүүлсэн удирдамжийг үндэслэн компанийн ТУЗ шийдвэрлэнэ гэж өөрчлөн найруулах тухай
3. Компанийн дүрмийн 10.9 дүгээр заалтыг хасах тухай
4. “Шивээ Овоо” ХК-ийн зарласан хувьцаанаас 10,261,665 ширхэг хувьцааг хөрөнгийн зах зээлд нэмэлтээр гаргаж нийтэд худалдах тухай;
5. Шинээр нийтэд худалдахаар гаргаж буй хувьцааг хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлүүлэхгүй байх нь зүйтэй гэж үзэх тухай
6. Хөрөнгийн зах зээлд нийтэд санал болгон худалдах хувьцааны санал болгох нэгжийн үнийг тогтоох эрхийг ТУЗ-д олгох тухай

3. Санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөр тогтоосугай.

4. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдрийг 2015 оны 10 дугаар сарын 5-ны өдрөөр, саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2015 оны 11 дүгээр сарын 4-ны өдрөөр тогтоосугай.

5. Хуралд бэлтгэх зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Хуралд бэлтгэх зохион байгуулах комиссын дарга:

О.Чинхүсэл /ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга/

Гишүүд:

Ж.Батмөнх/Захиргаа хүний нөөцийн бодлогын хэлтсийн дарга /

А.Энхгэрэл /Хуулийн зөвлөх/

Д.Золзаяа /Захиргааны мэргэжилтэн/

Хурлын тооллогын комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Тооллогын комиссын дарга: С.Одбаяр /ерөнхий нягтлан бодогч/

Гишүүдэд: Д.Ганбаатар УБТГ-ын дарга

С.Боргил ХХХ-ийн мэргэжилтэн менежер

6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар төрийн эзэмшлийн хувьцааны 90 хувийг эзэмшигч "Эрдэнэс Монгол" ХХК-аас санал өгөхөөр ирсэн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилсугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн танилцах материалын жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, санал авах хуудасыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

8. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /О.Отгонбаатар/-д даалгасугай.

ДАРГА



Б.АРИУНБОЛД

*“Шивээ Овоо” ХК-ийн ТУЗ-ийн 2015 оны 9 дүгээр сарын
29 өдрийн 25 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт*



**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ
ХОЛБОГДУУЛАН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД
ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Компанийн дүрмийн 4.1 дэх зүйлд өөрчлөлт оруулах тухай танилцуулга
2. Компанийн дүрмийн 12.6.3-д өөрчлөлт оруулах тухай танилцуулга
3. Компанийн дүрмийн 10.9 дүгээр заалтыг хасах тухай
4. Хөрөнгийн зах зээлд шинээр нийтэд санал болгон худалдах хувьцааны тооны талаарх танилцуулга
5. Шинээр нийтэд худалдахаар гаргаж буй хувьцааг хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлүүлэх эсэх талаарх танилцуулга
6. Хөрөнгийн зах зээлд нийтэд санал болгон худалдах хувьцааны санал болгох нэгжийн үнийг тогтоох эрхийг ТУЗ-д өгөх тухай танилцуулга

“Шивээ Овоо” ХК-ийн ТУЗ-ийн 2015 оны 09 дүгээр сарын 09 өдрийн 25 тоот тогтоолын хоёрдугаар хэсгээр хавсралт



“Шивээ-Овоо” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлаар хувьцаа эзэмшигчээс санал авах

САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

регистрийн дугаар

Хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн дугаар

Эзэмшиж буй хувьцааны төрөл

Тоо.....

д/д	Санал авах асуудлын нэр	Хурлаас гаргах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
1.	Компанийн дүрмийн 4.1 дүгээр зүйлд өөрчлөлт оруулах	Зарласан хувьцааны тоог 23,680,766 ш болгон өөрчлөх тухай				
2.	Компанийн дүрмийн 12.6.3-д өөрчлөлт оруулах тухай танилцуулга	эд хөрөнгө худалдан авах, данснаас хасах актлах асуудлыг толгой компаниас ирүүлсэн удирдамжийг үндэслэн компанийн ТУЗ шийдвэрлэнэ гэж өөрчлөх тухай				
3.	Компанийн дүрмийн 10.9 дүгээр заалтыг хасах тухай	Компанийн бизнес төлөвлөгөөг Компанийн ТУЗ шийдвэрлэх эрх олгох тухай				
4.	Хөрөнгийн зах зээлд нийтэд санал болгон худалдах хувьцааны тоог тогтоох	Шинээр 10,261,665 ширхэг хувьцааг хөрөнгийн зах зээлд нийтэд санал				

		болгон худалдах				
5	Шинээр нийтэд худалдахаар гаргаж буй хувьцааг хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлүүлэх эсэх	Тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлүүлэхгүй байх				
6	Хөрөнгийн зах зээлд нийтэд санал болгон худалдах хувьцааны санал болгох нэгжийн үнийг тогтоох	Нэгж хувьцааг борлуулах үнийг тогтоох эрхийг ТУЗ-д олгох				

Саналын хуудас хүлээн авах эцсийн өдөр дүгээр сарын болно.

Хувь эзэмшигчийн гарын үсэг

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон

Тооллогын комиссын дарга

гишүүд:
.....

Хүчингүйд тооцсон бол шалтгаан

Саналын хуудасны ар талд түүнийг бөглөх зааврыг бичих